

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНАЛ БОЛГОЖ БҮЙ БОНДЫН ХҮҮГИЙН ТҮВШИН

Эх сурвалж: Монгол банкны статистик

Үнэт цаас гаргагчийн олон нийтэд санал болгож буй “мах бонд”-ын хүүг арилжааны банкуудын хадгаламж, зээлийн хүүгийн түвшин болон МХБ дээр өмнөх хугацаанд гарч байсан бондын хүүг үндэслэн тодорхойлсон.

Мах бонд нь жилийн 16.2 хувь, сарын 1.35 хувийн хүүтэй бөгөөд энэ нь арилжааны банкуудын (монгол банкны статистик мэдээ, банкны системийн жигнэсэн дундаж, 2011 оны 4 сар) олгож буй хадгаламжийн дундаж хүүтэй харьцуулахад 51.4 хувь (5.5 нэгж) аар өндөр, зээлийн хүүгийн түвшинтэй харьцуулахад 0.6 хувь (0.1 нэгж) аар бага байна.

2001 оноос анх Монголын хөрөнгийн зах зээл дээр аж ахуй нэгж байгууллагууд бонд гаргах замаар хөрөнгө оруулалт татаж эхэлсэн бөгөөд үүнээс хойш нийт 13 компани бонд гаргасан байна. Хөрөнгийн зах зээлд гаргасан бондын хүүгийн судалгааг дараах графикаас харж болно.




График 13 Банк болон ААН-ийн бондын хүүгийн судалгаа




График 14 Компанийн бондын хүүгийн мэдээлэл

